



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/628

Алтай хот

Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Турк Улсын Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн Улаанбаатар дахь хөтөлбөрөөс тус аймагт сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2.Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг шинээр байгуулах, Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн удирдах багийг орон нутагт ажиллах үйл ажиллагаатай холбоотой зардал 1398500 (Нэг сая гурван зуун ерэн найман мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ